



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/75

Хэрлэн сум

Өвөлжилт хүндэрсэн зарим сумдад
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, аймгийн Онцгой комиссын №02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөлжилт хүндэрсэн зарим сумдыг хохирол багатай даван туулах, малчин иргэдэд төрийн болон эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах 40,000,000 (дөчин сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэг үзүүлэх сумдын нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2022 оны
... дугаар сарын ...-ны
... дугаар захирамжийн хавсралт

Дэмжлэг үзүүлэх сумдын нэрс

д/д	Сумдын нэрс	Мөнгөн дүн
1	Өмнөдэлгэр	10,000,000
2	Цэнхэрмандал	10,000,000
3	Жаргалтхаан	10,000,000
4	Баян-Адарга	10,000,000
	Нийт	40,000,000